

## БНСВУ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ ДАХЬ ШИНЭЧЛЭЛ

С. Дашцэвэл\*

1. БНСВУ-д хүнсний гол бүтээгдэхүүн нь цагаан будаа билээ. Цагаан будаагүйгээр вьетнам хүний амьдралыг төсөөлөх аргагүй. Манайхаар бол мах ч гэж хэлж болно. Энэ орон өнгөрсөн олон арван жил цагаан будаа хүрэлцээгүйгээс жил тутам 300-400 мянган тонныг гадаадаас авч байв.<sup>1</sup> Гэтэл сүүлийн жилүүдэд улс орноо хангаад зогссонгүй гадаадад үлэмжхэн хэмжээгээр гаргах боллоо. 1989 онд 1,4 сая тонн, 1990 онд 1,2 сая тонн цагаан будаа гадаадад гаргаж, дэлхийд хамгийн их цагаан будаа гаргадаг Тайланд, АНУ-ын дараа оров.<sup>2</sup> Цаашдаа 2 сая тонн хүртэл гаргах боломжтой гэж үзэж байна. Ийнхүү дутагдаж гачигдаж байсан гол хүнс-цагаан будааны үйлдвэрлэл харьцангуй богино хугацаанд үлэмж нэмэгдсэний нэг гол шалтгаан нь хөдөө аж ахуй дахь өнөөгийн шинэчлэлттэй холбоотой. Иймд Вьетнамын ХАА дахь шинэчлэлийн зарим туршлага бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа юм. Бидний бодоход Вьетнамд хоршооллын өмчийг эзэнд нь тууштай ойртуулж, үнийг чөлөөтэй болгож, зах зээлийн харилцаанд түргэн шилжсэн явдал амжилтын гол үндэс болжээ.

2. БНСВУ-д хөдөө аж ахуйг шинэчлэх бодлогыг 1980-аад оны эхнээс хэрэгжүүлж эхлэв. Шинэчлэлийн эхний жилүүдэд (1981—1988) хөдөө аж ахуйн хоршооллууд энгийн гэрээний хэлбэрийг өргөн ашиглав. Өөрөөр хэлбэл газрыг хамтран эзэмшиж, хөдөлмөрийнхөө нийт үр дүнг дахин хуваарилдаг хуучин аргыг халж, өрх бүр оногдсон газартай болж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гэрээт үүргийн дагуу хоршоололд нийлүүлж илүү гарснаа өөрөө хэрэглэдэг болов.

Энэ нь нийтийн нэг газар дээр ажиллаж, нийтийн тогооноос хувь хүртдэг байсан урьдын хэлбэрийг бодвол тариачдын хөдөлмөрлөх сонирхлыг ямар нэг хэмжээгээр төрүүлэхүйц давуу хэлбэр байв. Гэвч хоршооллын аж ахуйг эрхлэх энэ механизм өмчийг эзэнд нь төдийлөн ойртуулж чадсангүй. Яагаад гэвэл үйлдвэрлэлийн эцсийн үр дүн бусдаас хараат хэвээр, аж ахуйн хувьд бүрэн биеэ даах бололцоогүй байв.

Үйлдвэрлэл явуулж, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулж, аж ахуйн үйл ажиллагааг бие даан хийж байж сая өмч эзэндээ ойртож, өрх бүрийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болно гэдгийг ихэнх тариачид ухаарч эхэлсэн учир хөдөө аж ахуйн шинэчлэлийн 2-р үе 1988 оноос эхэлжээ. Юуны өмнө газрыг хоршооллын гишүүд удаан хугацаагаар буюу наад зах нь 15-аас доошгүй жилээр (үе залгамжлах эрхтэйгээр) түрээслэн эзэмшиж, үйлдвэрлэлийн бусад хэрэгслийг хоршооллоос худалдан авчээ. Өөрийн оногдсон газар дээр бие даан үйлдвэрлэл явуулж, аль болох их ашиг орлоготой аж ахуй болгохын төлөө хөдөлмөр авъяасаа дайчлах боломжийг тариачин өрх бүрд олгосон байна.

Хоршооллын захиргаа гишүүдийнхээ хөдлөх гишгэх бүрийг заан өгч, тэдний аж ахуй хөтлөх авьяас ухааныг нэг загвараар жолоодон идэвхгүй гүйцэтгэгчид болгодог хуучин зуршлаас салж, тариачдын хөдөлмөрийн эцсийн үр дүн буюу цэвэр орлогоос түрээсийн хураамж

\* С. Дашцэвэл — Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд эрдэмтэн

авах, үйлчлэх, зуучлах үүргийг голлон хийх боллоо. Ийнхүү тариачид үйлдвэрлэлийнхээ жинхэнэ эзэн болж, үйлдвэрлэл, борлуулалт, хуваарилалтад өөрөө оролцох болов. Энэ нь үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх тариачдын сонирхлыг нэн идэвхжүүлэв. Тариачид эрхэлсэн үйлдвэрлэлээсээ их ашиг олохын төлөө бүх чадал авъяасаа дайчлахын хамт газрыг ариг гамтай, зөв ашиглах, хөрсний бүтцийг сайжруулахын төлөө эрмэлзэж, усжуулах байгууламж барих, тутрагын талбайг өргөжүүлэх зэрэг ажилд хөрөнгө оруулах нь нэн идэвхжив. Жишээ нь: зарим мужид (Донг-Тан, Тьен-Занг) олон арван мянган га атаржсан газар сэргээн ашиглах, усжуулах барилга байгууламж, зам барихад нийт хөрөнгийн 4/5-ыг тариачид сайн дураараа гаргажээ.<sup>3</sup> Атаржсан газрыг эзэмших, усжуулах, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд улсаас ч үлэмжхэн анхаарч байна. Үүний тулд га-гаас авах ургацын хэмжээ мэдэгдэхүйц нэмэгджээ. Тухайлбал, 1983—1986 онд умард нутгийн зарим уулархаг болон тэгш өндөрлөгт га-гаас 22,8 ургац авч байсан бол 1989—1990 онд га-гаас 26,1 ц болж өсчээ. Меконг голын сав газар 1985—1986 онд 30 ц авч байсан бол 1989-1990 онд 36,4 ц болжээ. Улсын хэмжээний ургац 15,8 сая тонн-оос 19 сая тонн болж өсчээ.<sup>4</sup>

Хоршооллын гишүүд өрхийн бие даасан хэлбэрт орж байгаа нь хоршооллыг (нэгдлийг) үгүйсгэж байгаа хэрэг биш бөгөөд харин ч хоршооллын гишүүдийг өмчид нь ойртуулж үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, хоршооллыг аж ахуйн хувьд бэхжүүлж байна. Гишүүд нь чинээлэг бол хоршоолол чинээлэг байх нь дамжиггүй.

Өрхийн аж ахуйн түвшинд аж ахуйн бүх үйл ажиллагаа үр ашигтай байх нь үнийн бодлого, зах зээлийн харилцаа хэрхэн төгөлдөржсөнтэй холбоотой. Тийм учарас Вьетнамд юуны өмнө хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүний дотор хүнсний бүтээгдэхүүний үнийг чөлөөт зах зээлийн үнэд шилжүүлэв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед цагаан будааг дээрээс тогтоосон хэт хямд үнээр борлуулж байсан учир цагаан будааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд саад болж байв. Үүнээс гадна картын систем, хямд үнэ зэрэг нь илүү нөөцлөх сэтгэлгээ, зохиомол хомсдол бий болгож байв. Иймд 1988 оноос эхлэн цагаан будааны үнийг чөлөөтэй болгосон нь олон талын ашиг өгчээ. Юуны өмнө зохиомол хомсдолыг арилгаж зах зээлд бүтээгдэхүүн элбэгшиж эхлэв. Энэ үеэр улсаас цагаан будааг тодорхой хэмжээгээр нөөцлөх боломж ч бий болжээ. Одоо Вьетнамд цагаан будааны үнэ тогтворжиж зарим үед буурах хандлагатай байна.

Вьетнамд газар тариаланг заавал хамтын өмч байлгах албагүй гэж үзэж байна. Иймд зарим тариачид хоршооллоос гарч хувийн аж ахуйтан болжээ. Одоо вьетнамын хөдөө аж ахуйд хувийн, хоршооллын, улсын аж ахуй тэгш эрхтэй хөгжиж, дотоод, гадаадын зах зээлд чөлөөтэй өрсөлдөж байна.

Цагаан будааг гадаад зах зээлд гаргахдаа ХАА Яамны дэргэдэх хүнс-экспортын нэгтгэл, Хо Ши Мин хотын хүнсний нэгтгэл хоёроор гол нь дамжуулж гаргадаг боловч орон нутгаас бүтээгдэхүүн гадаадад гаргах ажлыг хөнгөвчлөх үүднээс тухайн нутагт гадаад худалдааны эрхтэй пүүсүүдийг олноор байгуулжээ. Экспортын өрсөлдөөнөөс гарч болзошгүй зарим сөрөг үр дагавраас зайлсхийхийн тулд цагаан будааг гадаадад гаргадаг пүүсүүдийн сайн дурын нийгэмлэг байгуулагдаж үнэ, борлуулалтаа уялдуулан зохицуулж байна. Энэ нийгэмлэг нь үнийн доод түвшинг тогтоох, орон нутгийн пүүсүүдэд зах зээл олж өгөхөд зуучлах, агуулах, зоорь, зам тээвэр зэрэг дэд бүтцийн зарим асуудлыг зохицуулж байна.

Хөдөө аж ахуйн багаж, техник, бордоо зэргийг улсаас хуваарилан

олгодгийг зогсоож тариачид орлогоороо зах зээлээс худалдан авч эхлэв. Харин түүний үнийг хямд байлгах талаар улсаас зориуд анхаарч байна. Мөн газар багатай нутгийн тариачид талбай ихтэй газар очиж ажиллах, зарим нь түрээс, гэрээгээр очиж хөдөлмөрлөх явдал чөлөөтэй болж ХАА дахь хөдөлмөрийн зах зээл идэвхжив. Үүнээс гадна хөдөө аж ахуйн хоршоолол, хөдөө орон нутаг дахь худалдаа бэлтгэлийн хоршоо, гар үйлдвэрлэлийн хоршоо, үйлчилгээний хоршоодын хооронд аж ахуйн хэлхээ холбоо бэхжиж төрөл бүрийн хоршоодын нэгдсэн сүлжээ бий болж бие биеэ тэтгэн хөгжиж байна.

\* \* \*

Дээр өгүүлснээс цэгнэн бодоход:

1. Манай ХАА дахь шинэчлэлийн гол зорилт бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх явдал бөгөөд үүнийг хэрэгжүүлэх гол цөм нь өмчийг эзэнд ойртуулах явдал юм. Вьетнамын туршлагаас үзвэл нэгдлийн (хоршооллын) өмчийг эзэнд нь ойртуулах гэдэг нь өрх бүр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чөлөөтэй борлуулж, хөдөлмөрийнхөө үр ашгийг мэдэрч байх боломжоор хангагдсан аж ахуйн бүхий л эрхийг гишүүддээ тууштай олгоно гэсэн үг ажээ. Нэгэнт өрхийг аж ахуйн бие даасан нэгж болгосон нөхцөлд зах зээлийн харилцааг боловсронгуй болгох нь нэн чухал ажээ. Юуны өмнө ХАА-н үйлдвэрлэлийн нэгж болсон-өрх бүр зах зээлд чөлөөтэй оролцоход төрийн зүгээс тус дэм үзүүлж, үнийн бодлогыг боловсронгуй болгож, эдийн засгийн дэд бүтцийг сайн бүрэлдүүлэхгүй бол өмчийг эзэнд ойртуулсан ч аж ахуйг үр ашигтай хөтлөн явуулах бололцоогүй ажээ.

2. Мах, сүү мэт хүнсний бүтээгдэхүүн манай орны хувьд онц чухал өргөн хэрэгцээтэй. Цагаан будаа бол Вьетнамын хувьд мөн онцгой бүтээгдэхүүн, Вьетнамд хамгийн өргөн хэрэглэгддэг энэ бүтээгдэхүүнийхээ үнийг чөлөөтэй болгосон нь бидний хувьд анхаарууштай байна. Үнийг чөлөөтэй болгохдоо барааны хангамж, худалдан авах чадвар буюу ард олны амьжиргааны түвшин зэрэг олон хүчин зүйлтэй уялдуулах нь зүйтэй боловч харьцангуй олон үйлдвэрлэгчтэй, өрсөлдөх боломж сайтай мах, сүү мэт (вьетнамаар бол цагаан будаа) хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг дээрээс хэт хямд тогтоох нь ХАА-д тулгуурласан орны эдийн засгийн хувьд ач холбогдолгүй ажээ.

1. Bao «Quan doi nhan dan» 9–5–1991
2. «Kint te va phat trien» Hanoi № 22 p. 4
3. Tap chi cong san, 1990 № 6 p. 17
4. Quan doi nhan dan, 9–5–1991

## **МЭДЭЭ, МЭДЭЭ, МЭДЭЭ**

## **ДЭЛХИЙН МАЛ АЖ АХУЙ**

Шинэ Зеланд улс 268103 ам км нутагтай 3 сая гаруй хүн амтай. Нийслэл Веллингтон. Албан ёсны хэл-англи

Шинэ Зеландын мал аж ахуй: Шинэ Зеландын малын тоо толгой: хонь 70 сая 500 мянга (1 хүнд 22 толгой хонь), үхэр-7 сая 600 мянга (1 хүнд 2,4 толгой үхэр). Бүх нутгийн 60 хувийг бэлчээр эзэлдэг. Сүүн бүтээгдэхүүн экспортолдоогоороо дэлхийд 1-р байранд ордог. Хонины ноосны экспортоор Австралийн дараа 2-р байр эзэлдэг, 1 хүнд ноогдох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээрээ (34400 доллар) хамгийн өндөр түвшинд хүрчээ. Шинэ Зеланд хонины ноос, махан бүтээгдэхүүн, бяслаг, цөцгийн тосны экспортоороо дэлхийд тэргүүлдэг.

Японы «JETRO» ЗАХ ЗЭЭЛИЙН ХУДАЛДАА  
ЦУВРАЛ НОМНООС АВАВ